



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/81

Баруун-Урт сум

Багшийн ёс зүйн зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/243 дугаар тушаалаар батлагдсан "Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, хариуцлага хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах бүхий орон тооны бус ёс зүйн зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Гишүүд:	Ц.Цэрэннамжил	- Мэргэжлийн хяналтын газрын боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч
	Л.Нарангарав	- Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Э.Хүрэлсүх	- Баруун-Урт сумын 4-р сургуулийн сургалтын менежер
	Ж.Өлзийсайхан	- Сүхбаатар сумын цэцэрлэгийн эрхлэгч
	М.Ганбаатар	- Баруун-Урт сумын 1-р сургуулийн нийгмийн ажилтан
	Ц.Түмэндэмбэрэл	- Баруун-Урт сумын 3-р сургуулийн бага ангийн багш
Зөвлөлийн нарийн бичгийн дарга:	Ш.Борчулуун	- Монгол улсын гавьяат багш
	Л.Байгалмаа	- Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

2. Багш, удирдах ажилтан болон бусад ажилтны ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах, урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргаж ажиллахыг с зүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга (Л.Байгалмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2019 оны А/462 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Handwritten signature of M. Idzerbat in black ink, written over a faint red rectangular stamp.

М.ИДЭРБАТ